**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 04 өдөр          Дугаар А/1276          Улаанбаатар хот

# Нийслэлийн өмчийн бүртгэлээс хөрөнгө хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 135 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй нийт 251,001,677.68 (хоёр зуун тавин нэгэн сая нэг мянга зургаан зуун далан долоон төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 189,409,990.96 (нэг зуун наян есөн сая дөрвөн зуун есөн мянга есөн зуун ерэн төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хавсралтад заасан 11 ширхэг ус түгээх байрыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т зөвшөөрсүгэй.

2.Акталж, данс бүртгэлээс хасагдаж буй барилгыг буулган хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах боломжтой түүхий эд материалыг үнэлэн худалдаж, худалдсанаас орох орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ (Д.Мөнхзул)-т даалгасугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ                    Х.НЯМБААТАР

1110205603

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
...11... дугаар сарын 04-ны өдрийн
...А/1276 дугаар... захирамжийн
хавсралт

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

(төгрөгөөр)

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Мэргэжлийн байгууллагын дүгнэлт | Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ус түгээх байр-932 СБД 16-р хороо | 5 | ш | 1 | 39,478,218.00 | 39,478,218.00 | 10,527,525.12 | 28,950,692.88 | Хөрсний геологийн судалгаа болон Хотын стандарт хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт 2024.03.22-ны өдрийн 02-13-01-032/110, 2024.04.08-ны өдрийн 02-13-01-036/125 тоот дүгнэлтээр ус түгээх байруудыг буулган шинээр барих. | 150,000.0 |
| 2 | Ус түгээх байр-928 БЗД 10-р хороо | 6 | ш | 1 | 37,139,893.00 | 37,139,893.00 | 1,451,466.70 | 25,688,426.30 | | 150,000.0 |
| 3 | Ус түгээх байр-959 БЗД 10-р хороо | 3 | ш | 1 | 6,408,243.00 | 66,408,243.00 | 9,684,535.35 | 56,723,707.65 | | 150,000.0 |
| 4 | Ус түгээх байр-947 СХД 24-р хороо | 4 | ш | 1 | 0,899,816.60 | 0,899,816.60 | 8,373,724.92 | 52,526,091.68 | | 150,000.0 |
| 5 | Ус түгээх байр-527 ЧД 19-р хороо | 24 | ш | 1 | 3,418,632.00 | 3,418,632.00 | 3,418,632.00 | 0.00 | | 150,000.0 |
| 6 | Ус түгээх байр-624 БГД 11-р хороо | 11 | ш | 1 | 2,898,126.00 | 2,898,126.00 | 2,898,126.00 | 0.00 | | 150,000.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Ус түгээх байр-726 СХД 23-р хороо | 12 | ш | 1 | 4,141,970.56 | 4,141,970.56 | 4,141,970.56 | 0.00 | | 150,000.0 |
| 8 | Ус түгээх байр-651 СХД 11-р хороо | 13 | ш | 1 | 3,855,600.00 | 3,855,600.00 | 3,855,600.00 | 0.00 | | 150,000.0 |
| 9 | Ус түгээх байр-632 СХД 14-р хороо | 14 | ш | 1 | 13,805,743.58 | 13,805,743.58 | 4,534,239.07 | 9,271,504.51 | "Толгойтын замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох, авто замын гүүрэн байгууламж, олон түвшний огтлолцол" авто замын ажлын нөлөөлөлд өртсөн. | 150,000.0 |
| 10 | Ус түгээх байр-627 СХД 12-р хороо | 6 | ш | 1 | 14,834,233.29 | 14,834,233.29 | 439,182.81 | 14,395,050.48 | | 150,000.0 |
| Зөөврийн ус хангах албаны барилгын дүн | | | | 10 | | 246,880,476.03 | 59,325,002.53 | 187,555,473.50 | | |
| 11 | Ус түгээх байр-003 БЗД 14-р хороо | 20 | ш | 1 | 4,121,201.65 | 4,121,201.65 | 2,266,684.19 | 1,854,517.46 | Баянзүрх дүүргийн 14-р хороо "Ахмадын хорооллын зүүн талаарх далан дагасан авто зам" барих авто замын ажлын нөлөөлөлд өртсөн. | 150,000.0 |
| Шугамаар ус хангах албаны барилгын дүн | | | | 1 | | 4,121,201.65 | 2,266,684.19 | 1,854,517.46 | | |
| НИЙТ ДҮН | | | | 11 | | 251,001,677.68 | 61,591,686.72 | 189,409,990.96 | | |